

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



**COVID-19 ХАЛДВАРЫН АЖИГЛАЛТЫН ҮЕИЙН ТУСГААРЛАН СЭРГИЙЛЭЛТ,
АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ**

Шинэ коронавируст (COVID-2019) халдварын сэжигтэй тохиолдолтой хавьтал болсон, халдварын голомтот бүс нутгаас ирсэн иргэдийг тусгаарлан ажиглалтад байх хугацаанд эрүүл мэндийн хяналтыг тавина.

Эрүүл мэндийн болон мэргэжлийн хяналтын хамтарсан баг ажиглалтын байрны бэлэн байдлыг хангуулахад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллана.

Нэг . Нийтлэг зүйл:

- 1.1. Хавьтал тусгаарлан ажиглах байр нь эмнэлэг, сувилал, зочид буудал, дотуур байр зэрэг байж болно. Нэг өрөөнд 2-оос дээш хүн байрлахаар зохион байгуулагдсан бол ор хоорондын зай 1м-ээс доошгүй байхаар төлөвлөнө. Өрөө бүрт ариун цэврийн өрөө, гар угаах нөхцлөөр хангагдсан байна.
- 1.2. Ажиглалтын байранд сэжигтэй тохиолдол илэрсэн үед түр тусгаарлах өрөө гаргасан байна.
- 1.3. Хэрэв ойрын хавьтлыг өрхийн эмчийн хяналтанд гэрийн нөхцөлд тусгаарлах бол гэр бүлийн бусад гишүүдээс тусдаа 1 өрөөнд өөрийгөө тусгаарлах боломжтой, ам бүл цөөн, нийтийн байр, оюутны байранд амьдардаггүй, гэр бүлийн гишүүд дотор ахмад настай, архаг суурь өвчтэй, нярай хүүхэдгүй байх зэргийг харгалзана.
- 1.4. Ажиглах байранд ажиглалтын хугацаанд эмч, сувилагч, үйлчилгээний ажилтан ажиллах бөгөөд ажиглалтад байгаа иргэдээс тусдаа байрлана.
- 1.5. Сэжигтэй тохиолдол илэрсэн үед хэрэглэх иж бүрэн хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, N95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай зэрэг)-ийг бэлтгэсэн байна.
- 1.6. Шаардлагатай тохиолдолд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх болон яаралтай тусламжийн эм, хэрэгслийг бэлэн байлгана.
- 1.7. Ажиглалтын өрөө бүрт гар халдваргүйжүүлэх уусмал байрлуулсан байна.
- 1.8. Ажиглалтад байгаа хүмүүсийн биеийн халууныг хэмжих хэрэгслийг хангалттай тоогоор бэлтгэж, хэвийн ажиллагааг хангаж ажиллана.
- 1.9. Ажиглалтын хугацаанд гаднаас ариун цэврийн хэрэгсэл, цаас, ном, бичгийн хэрэгсэл, хувцас, хоол (дахин хэрэглэх хоолны савгүй), сүү тараг, чихэр, жимс зэргийг эргэлтээр оруулж болно.
- 1.10. Ажиглалтын байранд үйлчилгээ үзүүлж байгаагаас бусад хүмүүс орохыг хориглоно.

Хоёр. Эрүүл мэндийн байгууллагаас анхаарах зүйл:

- 2.1. Ажиглалтын хугацаанд тухайн эрүүл мэндийн байгууллагаас хяналт тавих тохиолдолд эрүүл мэндийн ажилтан нь нэг удаагийн халад, мэс заслын амны хаалт, нэг удаагийн бээлий, малгайг өмсөж тусламж үзүүлнэ.

2.2. Ажиглалтанд байгаа хүмүүсийг бүртгэн халдварын шинж тэмдгийн тандалтыг хавсралт 1-д заасан хяналтын хуудсаар өдөр бүр хийж, халууныг өдөрт 2 удаа үзэн тэмдэглэл хөтөлж эрүүл мэндийн мэдээллийг ХӨСҮТ, харъяа ЭМГ-т мэдээлнэ.

2.3. Шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн ажилтаныг дуудах утасны дугаарыг ажиглалтын өрөөнд байрлууна.

2.4. Зовуурь, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг түр тусгаарлах өрөөнд тусгаарлан нийслэлд 100, орон нутагт харъяалах эрүүл мэндийн байгууллагад утсаар яаралтай мэдэгдэнэ.

2.5. Сэжигтэй тохиолдол илэрсэн үед эрүүл мэндийн ажилтан нь хамгаалах хувцас (комбинзон, N95 амны хаалт, нүдний шил, нүүрний хаалт, бээлий, малгай зэрэг)-ыг иж бүрэн өмсөж тусламж үзүүлнэ.

2.6. Сэжигтэй тохиолдолтой нэг өрөөнд хамт байсан иргэдийг өрөөнд нь тусгаарлан хяналт тавина.

2.7. Сэжигтэй тохиолдлыг ажиглалтын байрнаас тээвэрлэсний дараа халдваргүйжүүлэх үйл ажиллагааг Улаанбаатарт Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймагт Зоонозын өвчин судлалын төв, сум, тосгонд сум, тосгны эрүүл мэндийн төвийн мэргэжлийн багаар хийлгэнэ.

2.8. Эмнэлэг, сувиллаас бусад үйлчилгээний байрыг ажиглалтын байраар ашиглаж байгаа бол сэжигтэй тохиолдол илэрсэн үед түүний хог хаягдлыг аюултай хог хаягдал гэж үзэн, халдваргүйжүүлэлт хийсэн байгууллагад битүүмжлэн өгч явуулна.

2.9. Ажиглах байрны орчны цэвэрлэгээг ЭМС-ын 2019 оны А/537 дугаар тушаалын зургаадугаар хавсралтын дагуу хийнэ.

2.10. Ажиглалтын байранд өдөр тутам доорх зааврын дагуу халдваргүйжүүлэх үйл ажиллагааг хийнэ. Үүнд:

2.10.1. Цагаан өнгийн алчуураар шал, цэнхэр өнгийн алчуураар өрөө тасалгааны эд зүйлс, улаан өнгийн алчуураар ариун цэврийн өрөөний суултуурыг, шар өнгийн алчуураар ариун цэврийн өрөөний бусад эд юмсыг арчиж халдваргүйжүүлнэ; Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээний хэрэгсэл/хувин, шалны мод/ тусдаа байна.

2.10.2. Үйлчилгээний ажилтанд халдваргүйжүүлэх бодисыг найруулах арга, хэрэглээний талаарх мэдлэгийг заавал олгосон байна.

2.10.3. Байгууллагын дотоод орчинд халдваргүйжүүлэлт хийхийн өмнө эд юмсын гадаргуу дээрх тоос шороо, бохирдлыг арилгах, хог хаягдлыг зайлуулах зэргээр цэвэрлэгээг сайтар хийнэ.

2.10.4. Эд зүйлсийг урьдчилан найруулж бэлтгэсэн халдваргүйжүүлэх уусмалаар шүрших, арчих зэргээр халдваргүйжүүлэн, 15-30 минутын дараа цэвэр чийгтэй алчуураар сайтар арчина.

2.10.5. Халдваргүйжүүлэх уусмалд нэг алчуурыг дахин дахин дүрж норгохыг хориглоно.

2.10.6. Хүний гар хүрч халдваргүйжүүлэхэд төвөгтэй зай завсар, хэт өндөрт байрласан зүйлс зэргийг халдваргүйжүүлэхэд халдваргүйжүүлэх уусмалыг агаарт мананцар үүсгэн цацна.

2.10.7. Олон хүний гар хүрч амархан бохирддог компьютерийн гар, заагуур, гар болон телефон утас, хаалганы бариул, унтраагуур, цахилгаан шатны

- дотор орчин, цахилгаан шатны товчлуур, ширээ, шатны бариул, зурагтын удирдлага, сандлын түшлэг, ариун цэврийн өрөө зэргийг 2 цаг тутамд, мөн бохирлогдсон тохиолдол бүрт халдваргүйжүүлэх уусмалаар арчина.
- 2.10.8. Бөөлжис, нус, цэр, ялгадсыг салфетка, ариун цэврийн цаасыг ашиглаж, шингээж арчин, халдваргүйжүүлэх уусмалаар бохирдсон газар болон орчин тойрныг халдваргүйжүүлнэ.
- 2.10.9. Үйлчлүүлэгчдийн орны цагаан хэрэглэл, орны бүтээлэг, гар нүүрийн алчуур, зэрэг зөөлөн эдлэлийг агаарт сэгсэрч агаарын хөдөлгөөн үүсгэхгүйгээр зөөлөн хумьж аван, бохир хэрэгсэл зөөвөрлөх саванд хийж, угаалгын газарт хүргэнэ. Халдваргүйжүүлэх уусмалд 1 цагийн турш бүрэн дүрж халдваргүйжүүлсэний дараа угаалгын бодис ашиглан угааж индүүднэ.
- 2.10.10. Бохир хэрэгсэлтэй харьцаж ажиллаж буй ажилтан халад, хормогч, бээлий, ханцуйвч зэргийг заавал өмссөн байна.
- 2.10.11. Угаах боломжгүй орны зөөлөн эдлэл болох хөнжил, гудас, бүтээлэг, дэр зэргийг цэргийн хуаран, дотуур байр, хүүхдийн байгууллага, асрамжийн газар зэрэгт 7 хоног бүр гадаад орчинд гөвж сэгсрэх, нарны гэрлийн нөлөөг ашиглан физикийн аргаар халдваргүйжүүлнэ. Мөн дезкамер ашиглан уур, агаар, озоноор халдваргүйжүүлнэ.
- 2.10.12. Цонхны хөшиг, ширээ, суудлын бүтээлэг зэрэг зөөлөн эдлэлийг 7 хоног бүр угааж индүүднэ.
- 2.10.13. Ариун цэврийн өрөө, тосгуур, хөтөвч, угаалтуур, суултуур, банн зэргийг цэвэрлэсний дараа халдваргүйжүүлэх уусмал ашиглан дүрэх, арчих зэргээр халдваргүйжүүлнэ.
- 2.11. Сэжигтэй тохиолдол онош үгүйсгэгдсэн, ажиглалтын хугацаа дууссан тохиолдолд харъяалах байгууллагын шийдвэрээр хяналтыг зогсооно.
- 2.12. Ажиглалтад байгаа хүмүүст зориулсан хоолыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлага хангасан газарт үйлдвэрлэнэ.
- 2.13. Хоол үйлдвэрлэлийн газраас ажиглалтын байр луу хоол зөөвөрлөх бол зориулалтын халуун баригч бүхий битүүмжлэлтэй саваар зөөнө.
- 2.14. Эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан, баталгаажилттай түүхий эд, бүтээгдэхүүнийг хоол үйлдвэрлэлд хэрэглэнэ.
- 2.15. Хоол бүрээс зааврын дагуу дээж авч, 72 цагаас багагүй хугацаанд +4+8 хэмд хадгалж, бүртгэл хөтөлнө.
- 2.16. Ундны ус нь төвлөрсөн системд холбогдоогүй байрыг ажиглалтын байраар ашиглах бол мэргэжлийн хяналтын байгууллагаар ундны усны дээжид нян судлалын шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулна.

Гүрав. Ажиглалтад байгаа иргэдэд анхааруулах зүйл

- 3.1. Ажиглалтын байранд байгаа тохиолдолд өрөө хооронд сэлгүүцэх, бусдыг өдөөн турхирах, архи, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.
- 3.2. Өөрийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, ямарваа нэгэн зовуурь илэрсэн тохиолдолд эрүүл мэндийн ажилтанд утсаар үнэн зөв мэдээллийг өгнө.
- 3.3. Ажиглалтын хугацаанд гаднаас ариун цэврийн хэрэгсэл, цаас, ном, бичгийн хэрэгсэл, хувцас, хоол (дахин хэрэглэх хоолны савгүй), сүү тараг, чихэр, жимс зэргийг эргэлтээр авч болох бөгөөд гадагш гарах, эргэлтээр бусадтай уулзахыг хориглоно.

3.4. Эрүүл мэндийн болон харуул хамгаалалтын ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж, тэдэнд хүндэтгэлтэй харьцана.

3.5. Тухайн ажиглалтын байранд баримтлах дүрмийг ягштал биелүүлнэ.

3.6. Хэрэв гэрийн нөхцөлд ажиглалтад байгаа тохиолдолд гэрээс гарах, гэрт олон хүн цуглуулахгүй, олон хүнтэй хавьтал болохгүй байхыг анхааруулна.

ӨДӨР ТУТМЫН ХЯНАЛТЫН ХУУДАС:

Өдөр	Шянк тэмдэг						Бусад шянк тэмдэг: Бичих
	Шянк тэмдэг илрээгүй бол үгүй гэж тэмдэглэнэ.	Халуургах ≥38°C	Хоолой өвдөх	Хангалгах	Ядарч, сульдах	Амьсглагдах	
1	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
2	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
3	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
4	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
5	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
6	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
7	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
8	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
9	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
10	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
11	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
12	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
13	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	
14	<input type="checkbox"/> Үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй	